

**“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

дугаар № 01

Дархан-Уул аймаг

“Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Дархан нэхий ХК-ийн үйлдвэрийн байрны хурлын танхимд 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 12⁰⁰ цагт нийт 938,347,619 ширхэг хувьцаатай, хувьцаа эзэмшигчид оролцсоноор 84.88%-ийн ирцтэйгээр хурлыг хийлээ.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

1. Б. Дагвацэрмаа	29 087 000 ш	7. Батсайхан Чанцал	2 341 097 ш
2. Э. Батсайхан	326 903 000 ш	8. Ганхуяг Ган-Очир	1 166 683 ш
3. Б. Гэрэлмаа	7 800 000 ш	9. Самбуу – Ёндон Норжмаа	2 811 000 ш
4. Ж. Пүрэвсүрэн	50 000 ш	9. “ННТТ” ХХК	350 091 764 ш
5. Р. Сүмбэнхүү	218 097 075 ш	/итгэмжлэгдсэн төлөөлөгч С. Нарангарав/.	

Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс томилсон тухай шийдвэрийг ТУЗ-ийн нарын бичгийн дарга Х. Нарантуяа танилцуулав.

Э. Энхжаргал: Тооллогын комиссын дарга

“Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын бүртгэлийг хуулийн дагуу хийж, ирцийг мэдээлж, санал өгөх зааврыг танилцуулав. Тэрээр хувьцаа эзэмшигчид энэхүү хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №1-ээр, ТУЗ-ийн гишүүдийг сонгож санал өгөхдөө батлагдсан саналын хуудас №2-оор тус тус бичгээр өгнө. Харин ТУЗ-ийн гишүүнийг сонгох саналыг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 09 сарын 09-ны өдрийн 880 тоот тогтоолоор шинэчлэн баталсан “Санал хураах кумулятив арга хэрэглэх журам”-ыг баримтлан санал өгнө гэж журмыг тайлбарлан танилцуулав.

Хурлын дарга Э. Батсайхан:

“Хувьцаа эзэмшигчдийнхээ хуралд хүрэлцэн ирсэн Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэндээ талархал илэрхийлж, мэндчилэе.

“Тооллогын комиссын мэдээллээр хуралд оролцох Хувьцаа эзэмшигчдийн ирц 84.88%-тай байгаа тул хурлын ирцийг хангалттай гэж үзэж хурлаа эхлүүлж байна гээд хурлын дэгийг танилцуулав.

“Хуралд оролцогч та бүгдээс өөр санал байхгүй бол хурлын дэг ёсоор хэлэлцэх асуудлыг, асуудал тус бүрээр хэлэлцсэний эцэст хувьцаа эзэмшигчид батлагдсан саналын хуудсаар саналаа өгч, тооллогын комисс эцсийн шийдвэрийг гарган дүнг танилцуулна. Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж, /Өнөөдрийн хурлаар 5 асуудлыг хэлэлцэнэ. Одоо хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож батлах
4. Төлөөлөн удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах
5. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулж батлах

Хэлэлцсэн нь:

1 ба 2-р асуудал:

Дархан нэхий ХК-ийн гүйцэтгэх захирал Б. Гэрэлмаа ДНХК-ийн 2025 оны үйл ажиллагааны нэгтгэл тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Тайланг хавсаргав.

Э. Батсайхан /ТУЗ-ийн дарга/

Хувьцаа эзэмшигчдэд КтХ-ын 96.4-д заасан мэдээллийг болон ДНХК-ийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн дүгнэлтийг хамтатган мэдээллээ.

-Ерөнхий мэдээлэл: Тайлант үе: 2025 он, Хувьцаа эзэмшигчдийн тоо: 6601 хувьцаа эзэмшигч 2025 оны 3 сарын 25 –ны байдлаар бүртгэлтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн тооны өөрчлөлт: Өнгөрсөн оноос 455 хувьцаа эзэмшигчээр нэмэгдсэн үзүүлэлт юм. Мөн Хашид арвижах хамтын ХОС ХХК, Бат инвестмент сан ХХК гэсэн хоёр ХОС компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэгджээ.

-Бүтэц, зохион байгуулалтын талаар: -Тайлант хугацаанд Дархан нэхий ХК-ийн үйл ажиллагааны бүтэц өөрчлөгдөөгүй. 2025 онд энэ зохион байгуулалтаар Дархан нэхий ХК-ийн 7 охин компаниуд ТУЗ-өөр батлагдсан төсөв, орон тоо, бүтцийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Үүнээс 1 охин компани төлөвлөгөөт зорилгоо ханган биелүүлсэн бол бусад үйлдвэрлэлийн чиглэлийн 5 компани, Дэвжих нэхий ББСБ тавьсан зорилтоо бүрэн ханган биелүүлж чадсангүй.

-Хүний нөөцийн мэдээлэл: Нийт ажиллагсад (тоо): 279 ажилтан Шинээр нэмэгдсэн/бууруулсан орон тоо: 92 ажилтнаар буурсан. Ажилтнуудын орон тоо буурснаар дагаад үйлдвэрлэл буурах үндсэн шалтгаан болсон. Ажиллах хүчний хомсдлыг нөхөх зорилгоор Бангладеш улсаас 12 ажилтан авч одоогоор 10 ажилтан ажиллаж байна. Сургалт, хөгжлийн үйл ажиллагаа: санхүү бүртгэлд удирдлагын бүртгэл нэвтрүүлэх сургалтыг явуулсан. Мөн төсвийн төлөвлөлтийн сургалтыг удирдах ажилтнуудад эзэмшүүлсэн. Ажилтнуудын дундаж цалинг 3 сая төгрөгт хүргэх зорилт тавьсан боловч дундаж цалин 2,447,145 төгрөг болж урд оны дунджаас 14 % өсөлттэй байна.

-Компанийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийн тайлан

Зорилго, зорилт: Компанийн бүтэц зохион байгуулалтыг хэвээр хадгалж удирдлагын зардлыг өсгөхгүй байх, зах зээлийн борлуулалт, хэрэглэгчийн худалдан авах чадвар муудсантай холбоотой төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхээс илүүтэй захиалгат борлуулалтанд анхаарч, алдагдлыг багасгах зорилт тавьж ажилласан. 48,7 тэрбум борлуулалт хийхээр бизнес төлөвлөгөө батлагдсан боловч зах зээлийн хямралт байдлыг харгалзан компанийн зүгээс ажилтны тоо, үйлдвэрлэлийг нэмэхгүй чиглэл барьж ажилласан учир 25,0 тэрбумын борлуулалт хийж төлөвлөгөөний биелэлт -49 %, өмнөх онтой харьцуулбал -16% хувийн бууралттай гарлаа. Ашгийн төлөвлөгөө 4,7 тэрбум болж төлөвлөснөөс 43%, өмнөх оноос 23% буурлаа. Охин компаниудын борлуулалт өмнөх оны борлуулалтаас Як Трейд ХХК 47%, Нэхий Гармент ХХК 45% буурсан, Нэхий таннери ХХК -37%. Нэхий Трейд ХХК 13%-иар тус тус буурч Як ланд ХХК 1 % өсөлттэй, Дэвжих нэхий ББСБ 6%, Гранд як ХХК 8% өсөлт тус тус гаргажээ. Борлуулалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа 2025 оны бизнес төлөвлөлтөөр бус өнгөрсөн оны гүйцэтгэлээс буурахгүй байх чиглэлийг зах зээлийн байдлыг харгалзан охин компаниудад өгсөнтэй холбоотой юм. Ашгийн төлөвлөгөө Гранд як ХХК 10% давуулж бусад компаниуд биелүүлсэнгүй. Компаниудын ашиг өмнөх оноос Дэвжих Нэхий ББСБ -37%, Як Трейд ХХК -98 %, Нэхий Гармент ХХК -106%-иар буурсан, Нэхий таннери ХХК -45%, Нэхий Трейд ХХК -106 Як ланд ХХК 114 %-иар тус тус буурч, нийт дүнгээр -23% бууралттай гарчээ. Төлөвлөгөөний биелэлт муу гарсан нь худалдааны салбарт нийтдээ борлуулалт 40-50% унасан, үүнийг тооцож үйлдвэрлэлийг багасгасантай холбоотой.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ: Компанийн хуримтлагдсан өр төлбөрүүдийг багасгах, төлбөрийг хугацаанд нь хийж нийлүүлэгчдээ тогтоон барих бодлого

барьж татварын хуримтлагдсан өрийг барагдуулах ажлыг хийж одоо 2023 оноос өмнөх өрийг барагдуулсан дүнтэй байна. Нэхий таннери компани Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр бизнесийн шинэ чиглэл нэмэх арга хэмжээ авч ноосон дотор, улавчны эсгий үйлдвэрлэх зорилгоор эргэлтийн зээл, хөрөнгө оруулалтын зээл тус тус авч ноос боловсруулах үйлдвэрлэл эхлүүлээ. Мөн Нэхий таннери ХХК-д түүхий эд бэлтгэлд зориулан 1,5 тэрбум төгрөгийн зээл авсан. 3,077 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Гутлын үйлдвэрлэл ажиллах хүчний хомсдолд орсон учир ажлын гутал үйлдвэрлэлийг автоматжуулах шаардлага үүссэн учраас 5 тэрбум төгрөгийн автомат оёдлын шугам, гутлын цутгуур улны автомат суурилуулж ээлжиндээ 800 хос гутал гаргах хүчин чадалтай боллоо. Ингэснээр бүтээмж 10 дахин өсөж ажилтны тоо мөн хэмжээгээр буурах нөхцөл үүссэн. Байнгын гэрэлтүүлэг шаардлагатай подвалын хэсэгт байрласан цехүүдийн гэрэлтүүлгийг 11,7 квт нарны гэрлээр шийдэж, жилд 6 орчим төгрөгийн цахилгааны зардлыг бууруулсан. Хөрөнгө оруулалтаа 3 жилд нөхнө. Мөн компанийн олон жил засвар үйлчлэгээ хийгээгүй байсан боловсруулах үйлдвэрийн цех тасгуудын засвар үйлчилгээг хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг оновчлох, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажилласан жил боллоо.

1. Үйл ажиллагааны онцлох үр дүн:
 - Амжилттай хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ: Ажлын гутлын үйлдвэрлэл автомат оёдол, бүрэн цутгамал уланд шилжсэн.
 - Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ: ноосон дотор, улны эсгий үйлдвэрлэл эхэлсэн
 - Санхүүгийн бүртгэлийг улирлагын бүртгэлд шилжүүлж, программ хангамж нэвтрүүлэх бэлтгэлийг хангалаа.
2. Гүйцэтгэлийн үнэлгээ хяналт:
 - 4 компанийн санхүүд аудитын шалгалт хийгдсэн.
 - Илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ: санхүүгийн сахилга бат сул, гүйцэтгэлийн хяналтууд хийдэггүй зөрчил илэрсэн.
 - Хэрэгжилтийн түвшин: санхүүгийн үйл ажиллагаа сайжирсан.
 - Ашгийн төлөвлөгөө биелүүлсэн Гранд як ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мягмар Өлзийд 128,093 сая төг, ерөнхий нябо 44,145 сая төгрөг, ажилтнуудад олгосонтой нийлээд нийт 254,6 сая төгрөг олгохоор шийдвэрлэсэн.
3. Дүгнэлт ба санал:
 - Тайлант хугацаанд гарсан үр дүнгийн дүгнэлт: 2025 оны хувьд компани стратегийн зорилтоо зөв тодорхойлож, эрэлт хэрэгцээ буурч буй уламжлалт бүтээгдэхүүнээ шинэчлэн бүтээгдэхүүнээ шинэчлэх ажлуудыг хийсэн.
 - Сүүлийн үеийн дэвшилтэд технологийг Гутлын үйлдвэр, ноос боловсруултын салбарт нэвтрүүллээ.
 - Салбарын хэмжээнд зах зээлийн худалдан авалт 40 орчим % буурсан хямралт цаг үед сайн ажиллаж, өнгөрсөн оны борлуулалтын түвшинд барьж ажиллаж чадлаа.
4. Цаашид анхаарах асуудал, санал, зөвлөмж:
 - цаашид шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн хүчин чадлыг бүрэн ашиглах, гадаад зах зээл анхаарч ажиллах шаардлагатай.
 - Хямралын байдал 2026 онд улам ужигарч магадгүй байгааг харгалзан төлөвлөлтийг богино хугацаагаар хийж, захиалгат үйлдвэрлэлд анхаарч ажиллах

Санхүүгийн тайлангийн дүгнэлтийн талаар: 2025 онд санхүүгийн хувьд тайлан мэдээг стандарчлах, мөнгөн үлдэгдлийн эргэлтийг сайжруулах, бүтээгдэхүүний өртгийг нарийвчлах бүтээгдэхүүний үнийг зах зээлийн өрсөлдөх хэмжээнд байлгах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн байдал тогтворжих хандлагатай болж төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нэмэгдсэн. Хөрөнгийн талаар: хувьцаа урт хугацаат хөрөнгө оруулалтанд шилжсэн санхүүгийн бичилт хийгдсэн. Өр төлбөр: компани мөнгөний хатуу бодлого барьж урсгал зардлаас бусад зардлыг хатуу танаж орлогоос хадгаламж үүсгэж эрсдийн сан үүсгэн ажиллаж 8,7 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламж үүсгэсэн нь өр төлбөрийн дарамт үүсэхээс сэргийлсэн сайн арга хэмжээ болжээ. Хөрөнгө оруулалтын талаар: Гранд як-н фасад засвар, 16 айлын сууц зэрэг хөрөнгө оруулалтын гүйцэтгэл энд ороогүй бөгөөд 2026 оны балансад гүйцэтгэлээр сууна. Гутлын үйлдвэрийн оёдол, улагааны тоног төхөөрөмж шинэчлэгдэж, ул цутгуур, автомат оёдлын шинэ технологүүд эзэмшсэн. Мөн ноосоор улны эсгий хийх, сентофоныг орлох ноосон дотор хийх шугмууд суурилуулсан нь гутлын эсгий улавч, ажлын хувцасны дотрыг дотооддоо үйлдвэрлэн хангах боломж нээсэн байна. Гранд як ХХК зочид буудал, бизнес төвийн фасадыг орчин үеийн металл хавтан, шилэн хөвөнгийн дулаалгаар хослон шийдэж өнгө үзэмж, аюулгүй байдлаа сайжруулах томоохон хөрөнгө оруулалтын ажил хийж 80% гүйцэтгэлтэй байна. Цаашид анхаарах зүйлс: 1. Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ашиглалтгүй хөрөнгөнүүдийг зарж борлуулж хуримтлал үүсгэх шаардлага үүссэн. Үүнийг 2026 онд шийдвэрлэх хэрэгтэй. 2. Удирдлагын бүртгэлд шилжиж дата бааз бүрдэж буй тул ХОУ-г нэвтрүүлэн зардлыг бууруулах, бүртгэл мэдээллийг автоматжуулан, мэдээллийн удирдлагад шилжих ажлыг яаралтай хийх шаардлагатай. 3. Зах зээлийн байдал улам бүр муудах хандлагатай байгааг харгалзан төсөв төлөвлөлтийг цаг үеийн байдалд тохируулан богино хугацаагаар төлөвлөж байх

Э. Батсайхан:

-Дархан нэхий ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ээс өгсөн дүгнэлт болон КтХ-ийн 96.4-д заасан ТУЗ-ийн ажлын тайлантай холбоотой асууж тодруулах саналаа хэлэхийг хуралд оролцогчдоос хүслээ. Мөн гүйцэтгэх захиралд хандаж тайлангаа санхүүгийн балансад тусгасан тоо баримтаар хийх хэрэгтэй. Манай тоонууд зөрөөд байгааг цаашид анхаарах.

Ж. Пүрэвсүрэн: Хувьцаа эзэмшигч

-Тайлан, дүгнэлтийг маш сайн ил тод байдлаар дэлгэрэнгүй танилцууллаа. Охин компаниудын үзүүлэлт буурсан байна. 2 охин компани борлуулалт буурсан байна

Э. Батсайхан:

-Тиймээ үйлдвэрийн чиглэлийн 2 компани ашиггүй ажилласан байгаа. Яаж ч хичээгээд борлуулалт явагдахгүй байна. Мөн жижиг зээлүүд төлөгдөхгүй байна. Том хөрөнгө оруулалт хийгдсэн. Хямралт байдал хэдийд цэгцэрч дуусах юм. Чиглэл өөрчлөх бодлого барьж байна. Уламжлалт нэхий борлуулалт зогсонги болж байна. Тэлий, цүнх оруулна. Нэхий бүтээгдэхүүний хэрэглээ багассан. Сентфонд шилжсэн. Цэргийнхний тендерийн хувцасны стандарт өөрчлөгдөж, нэхий нь сентфон болсон. Иймд чиглэл өөрчлөх хэрэгтэй байна. Уламжлалт бүтээгдэхүүний өөрчлөлтийн талаар сайн ойлгуулах хэрэгтэй.

Ж. Пүрэвсүрэн:

-Нэхийг юу тодорхойлох вэ. Уламжлалт бүтээгдэхүүний чиглэл өөрчлөх хэцүү дээ.

Э. Батсайхан:

-Ноосоор ажлын хувцасны дотор үйлдвэрлэж эхэлсэн.

Р. Сүмбэнхүү:

-Бүтэн жилийн ажлын үр дүнгийн тайланг сонслоо. Тайланд маш гарлаа. Хүний нөөцийн хомсдол, борлуулалт буурсанаас үүдэлтэй үзүүлэлт буурсан байна. Тайланг хангалттай гэж үзье гэсэн санал байна.

Ж. Пүрэвсүрэн:

-Бодлогын түвшинд өөрчлөлт хийх юм байна гэсэн хүлээлт үүссэн. Удирдлагын хувьд туршлагатай хүн ирсэн байна. Охин компаниуд сайн ажиллахгүй байна уу гэж бодож байна. Тайлан хангалттай байна. Нэхий авах хүн багассан нь бодит үнэн. Үлдэгдэл бараа хэр багассан вэ.

Э. Батсайхан:

-Барааг хямдруулан нилээд борлуулсан. Үлдэгдлийг бууруулахын тулд хямдралын ажил сайн зохион байгуулсан. Үүний дүнд маш их буурсан. Цаашид ч үргэлжлүүлнэ. Хуучирч удаан хадгалагдсан барааг Актлаж, устгаж цэгцлэнэ.

Э. Батсайхан:

- ТУЗ-ийн тайлангаар холбоотой санал байна уу? Өөр асуулттай хүн байна уу. За санал, асуулт, тодруулах зүйл байхгүй бол дараагийн асуудлыг хэлэлцье.

3-р асуудал:

Э. Батсайхан:

-ТУЗ-ийн гишүүнийг сонгож, батлах асуудлыг хэлэлцье. ТУЗ-д нийтдээ 11 иргэн нэр дэвшсэн бөгөөд үүнээс ТУЗ-ийн ердийн гишүүнд 5 иргэн, хараат бус гишүүнд 6 иргэн тус тус нэр дэвшсэн байна. Нэр дэвшигчдийн анкет, хараат бус гишүүний шалгуурыг хангасан эсэх талаархи мэдээллийг нэр дэвшигч тус бүрээр товч танилцууллаа. ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо санал хураах кумулятив арга хэрэглэх журам"-ын дагуу өгөхийг дахин санууллаа. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 5 нь ердийн, 4 нь хараат бус гишүүн байна.

-Одоо дараагийн асуудалд оръё.

4-р асуудал:

Э. Батсайхан:

-ДНХК-ийн 2026 оны ТУЗ-ийн төсвийн төслийг танилцуулаад, төсөлд оруулах санал байна уу. ТУЗ өмнөх оны төсвийн гүйцэтгэл 78,7% байсан. Төсөв хэмнэгдэж ирсэн байгаа. Иймээс гүйцэтгэлийг 9,6-10 % -иар өсгөн тооцож, 2026 оны ТУЗ-ийн төсвийг 86,6% байхаар оруулсан байна.

5-р асуудал:

Э. Батсайхан:

2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд "Ногдол ашиг хуваарилах тухай" 2026 оны 02 сарын 15-ны өдрийн 26/10 тоот ТУЗ-ийн тогтоолыг уншиж танилцуулав.

Э. Батсайхан: хурлын дарга

-За хурлын асуудлуудыг хэлэлцэж дууссан бол саналын хуудсаа бөглөцгөөе.

Ингээд хурлаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууссан тул хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар саналаа өгч, тус бүрийн саналын хуудсыг тооллогын комисс хүлээн авч, дүгнэн эцсийн дүнг танилцуулж, Дархан нэхий ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 01, 02, 03 шийдвэрийг тооллогын комиссын Э. Энхжаргал уншиж танилцуулав.

1. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналын дүн:

Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах, Компанийн тухай хуулийн 96.4-д заасан тайланг танилцуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож батлах, Төлөөлөн удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах, Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай ТУЗ-өөс гаргасан шийдвэрийг танилцуулж батлах тухай шийдвэр гарсныг тус тус танилцуулав.

2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын дүн:

Санал хураалтаар доорхи 9 гишүүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгож, үүнээс ердийн гишүүнд 5, хараат бус гишүүнд 4 нэр дэвшигч сонгогдсон тухай дүнг танилцуулав.

1. ТУЗ-ийн ердийн гишүүнээр:

1. Эрдэнэдалай Батсайхан - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84,88 хувийн саналаар;
2. Равжаа Сүмбэнхүү - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84,88 хувийн саналаар;
3. Баасан Гэрэлмаа - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84,88 хувийн саналаар;
4. Батсайхан Мягмар-Өлзий - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84,88 хувийн саналаар;
5. Ганхуяг Ган-Очир - Хуралд оролцогчдын 100% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84,88 хувийн саналаар;

2. ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

6. Ринчин Бямбадорж - Хуралд оролцогчдын 64,91% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 55,1 хувийн саналаар.
 7. Мягмардорж Ганзориг - Хуралд оролцогчдын 99,7% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84,63 хувийн саналаар;
 8. Баатар Бурмаа - Хуралд оролцогчдын 99,75% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 84,67 хувийн саналаар;
 9. Магван Оюунчимэг - Хуралд оролцогчдын 96,77% саналаар буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 82,14 хувийн саналаар;
- тус тус сонгогдсон байна.

Дархан нэхий ХК-ийн 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрүүдтэй холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараахь шийдвэрийг гаргалаа.

Хурлын шийдвэр:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ийн дүгнэлт, ТУЗ-ийн тайланг батлах
2. Сонгогдсон нэр бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг батлах
3. Төлөөлөн удирдах Зөвлөлийн 2026 оны зардлын төсвийг батлах
4. Ногдол ашиг хуваарилах, эсэх тухай 26/10 тоот ТУЗ-ийн шийдвэрийг батлах

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТАНИЛЦСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ХУРЛЫН ДАРГА

Х.НАРАНТУЯА

Э. БАТСАЙХАН